МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ГАЗАРЗҮЙ, ГЕОЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН
2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТ

Аудитын код: САГ-2018/196/СТА-ТШЗ

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

2018 он

ҮАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**Аудитын код: САГ-2018/196/-СТА-ТШЗ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг даараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn


Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл
Утас: 261885 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Аудитор Д.Цэрэндорж
Утас: 261740 Цахим хаяг: tserendorjd@audit.gov.mn

Юнистар аудит ХХК-ийн
Аудитор Б.Тэрбиш
Утас: 328735 Цахим хаяг:unistar_audit@yahoo.com

Хаяг: УБ хот, Сүхбаатар дүүрэг 8 дугаар хороо Мигма төв байр 306 тоот


01
ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Улаанбаатар хот
**2018 оны 2 дугаар сар**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ....................2
2. Аудитын тайлан....................4
2.1 Оршил....................4
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг хариуцлага....................4
2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчин....................5
2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн....................5
2.5 Дотоод хяналт....................6
2.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар тодруулга....................6
2.7 Шилэн дансны мэдээлэл....................6
2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар....................7
2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл......7
2.9.1 Авлагын талаар....................7
2.9.2 Бараа материал, үндсэн хөрөнгийн бүртгэлийн талаар....................7
2.9.3 Урьдчилж төлсөн зардал тооцоо....................8
2.9.4 Үндсэн хөрөнгийн талаар....................8
2.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал....................8
2.11 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд....................8
2.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл....................8
2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....................8
2.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар....................9
2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл....................9
3. Менежментийн захидал....................10
3.1 Авлагын талаар....................12
3.2 Урьдчилж төлсөн зардлын талаар....................13
3.3 Бараа материал, үндсэн хөрөнгийн бүртгэлийн талаар....................14
3.4 Үндсэн хөрөнгийн талаар....................15
4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан....................16
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан....................18
4.3 Аудит хийгдсэн Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан....................21
4.4 Аудит хийгдсэн Мөнгөн гүйлгээний тайлан....................22
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан....................25
4.5 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан....................27

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ





01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2018.02.23 № 06/526
танай ____________-ны № ____________-т

ГАЗАРЗҮЙ, ГЕОЭКОЛОГИЙН
ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ
Д.БАТТОГТОХ ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ



01 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

070753

**Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

УХА0122

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

## 2. Аудитын тайлан

### 2.1. Оршил

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн захирал Д.Баттогтох танд танилцуулж байна.

Энэ тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд өглөг авлагын үлдэгдлийг харилцагч бүрээр тооцоо нийлж, актаар баталгаажуулж байх, авлагаа барагдуулах ажил зохион байгуулах, цаашид өр авлага үүсгэхгүй байх хуулийн заалтыг биелүүлж ажиллах, урьдчилж төлсөн зардал тооцоог суутган тооцох, тооцоог цаг тухай бүр зохих ёсоор хийж хэвших, УСНББОУС-ын дагуу хөрөнгийг зөв ангилж бүртгэх, салбарын бүртгэлийн бодлогодоо нийцүүлэн өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон НББББББ боловсруулж мөрдөх, Үндсэн хөрөнгө худалдан авахдаа хууль журмын дагуу зохих зөвшөөрлийг авч байх, цаашид зөрчил гаргахгүй байх зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 01 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 01 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитыг 2018 оны 1 дүгээр сарын 23-наас 2018 оны 2 дугаар сарын 23-ны хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын захиалгаар Юнистар Аудит ХХК-ийн ахлах аудитор Б.Тэрбиш ахлагчтай баг гүйцэтгэв.

Газарзүй, геоэкологийн хүрээлэн 2017 оны санхүүгийн тайлангаа 2018 оны 2 дугаар сарын 01-ний өдрийн 1/64 дугаартай албан бичгээр Юнистар Аудит ХХК-д төсвийн тухай хуулиар тогтоосон хугацааг 8 хоног хоцроон ирүүлсэн.

### 2.3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Газарзүй, геоэкологийн хүрээлэн нь Монгол орны газарзүй, хүрээлэн буй орчны чиглэлээр шинжлэх ухааны суурь болон хавсарга судалгаа явуулах эрдэм шинжилгээний мэргэжлийн төрөлжсөн байгууллага юм. Хүрээлэн нь Монгол орны физик газарзүй, геоэкологийн онцлог, байгалийн хувьсал өөрчлөлт, газар ашиглалт, газрын болон усны нөөц, хөрс бэлчээрийн ургамал, экологи цөлжилтийн төлөв байдал, тэдгээрийн хувьсал өөрчлөлтийн харилцан шүтэлцээг тодорхойлж аж ахуйн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн урьдчилан судлан тогтоох, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах нөхөн сэргээх, экосистемд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах шинжлэх ухааны үндэслэлийг орчин үеийн онолын судалгааны түвшинд боловсруулах, судалгаа шинжилгээний үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх суурь ба хавсарга судалгааг явуулах үндсэн үүрэгтэй.

Тус хүрээлэн нь Шинжлэх ухаан технологийн тухай, Шинжлэх ухааны академийн эрхзүйн байдлын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай болон холбогдох бусад хуулиуд, УСНББОУС, Сангийн сайдын 2006 оны 388, 2008 оны 352 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”-ыг ашиглаж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хуульд өөрчлөлт ороогүй байна.

### 2.4. Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд АОУС, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000–1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 01 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 01 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Аудитаар Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Гүйцэтгэлийн шатанд санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан 16 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг Acolous 4.0 програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

**2.5. Дотоод хяналт**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Байгууллагын дотоод хяналт Төсвийн тухай болон холбогдох бусад хууль, байгууллагын дүрэм, дотоод журам, үр дүнгийн гэрээ, ажил үүргийн хуваарийн дагуу хийгддэг. Захирлын дэргэд Эрдмийн зөвлөл, Захиргааны зөвлөл ажилладаг. Захирал хүрээлэнгийн бүхий л үйл ажиллагаанд чиг үүргийнхээ хүрээнд хяналт тавьж ажиллаж байна.

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байлаа.

**2.6. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Батлагдсан төсвийн санхүүжилтийг хуваарийн дагуу Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжилт авч үйл ажиллагаа явуулсан байна.

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2017 оны төсөв улсын төсвийн санхүүжилтээр 1,619,927.0 мянган төгрөг, өөрийн орлогоор 24,500.0 мянган төгрөг нийт 1,644,427.0 мянган төгрөгийн орлого төсөвлөгдсөн бол гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,612,601.9 мянган төгрөг, өөрийн орлогоор 21,642.3 мянган төгрөг, нийт 1,634,244.2 мянган төгрөгийн орлоготой ажилласан. Тайлант онд нийт 1,613,948.26 мянган төгрөг зарцуулсан байна. 176,514.2 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт авсан.

**2.7. Шилэн дансны мэдээлэл**

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Газарзүй геоэкологийн хүрээлэн нь Шилэн дансны цахим хуудсанд нийтлэх мэдээллийн агуулга,нийтлэг стандартыг тогтоох тухай журам, Санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдал, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зарчмын дагуу 5.0 сая төгрөгөөс



01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

дээш худалдан авалт 26 удаа, батлагдсан төсвийн гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгааны тайлбарыг сар, улирлаар оруулсан байна.

**2.8. Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар**

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 6 дансанд эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд хяналтын болон нарийвчилсан горим, сорил 16-г гүйцэтгэв.

**2.9. Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл**

Газарзүй, геоэкологийн хүрээлэн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, үйл ажиллагааны орлого, үйл ажиллагааны зардал зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгахад /ТАБ-СТА-В-3/ дараах зөрчилтэй асуудлууд илрэв. Үүнд:

**2.9.1. Авлагын талаар:**

Газарзүй, геоэкологийн хүрээлэн тайлант оны эцэст 118,053.58 мянган төгрөгийн авлагатай тайлагнасан. Тайлангийн тасалбар болгосон өдрөөр авлагын үлдэгдлийг харилцагч нэг бүрээр тооцоо нийлж акт үйлдэж баталгаажуулаагүй байна. Аудитын тулган баталгаажуулалт хийх явцад 2 харилцагчийн 86,750.0 мянган төгрөгийн авлагын тооцоо нийлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж, өр авлага үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д “...бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж, харилцагч тус бүрээр авлагын тооцоо нийлж, актаар баталгаажуулах, авлагаа барагдуулах зөвлөмж өгөх.

2.9.2. **Бараа материал, үндсэн хөрөнгийн бүртгэлийн талаар.**

Бараа материалын дансанд 19,538.0 мянган төгрөгийн усалгааны систем, 3.500.0 мянган төгрөгийн хүлэмж зэрэг үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна. Мөн ашиглалтанд олгосон хангамжийн материалыг бараа материалын дансанд бүртгэгдсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3.”холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар...баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартын дагуу хөрөнгийг зөв ангилж бүртгэх, салбарын бүртгэлийн бодлогодоо нийцүүлэн өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон НББББББ боловсруулж мөрдөх талаар зөвлөмж өгөх.

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ



01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

2.9.3. **Урьдчилж төлсөн зардал тооцооны талаар.**

Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл 6,033.8 мянган төгрөг байна. Аудитын явцад нягталж үзэхэд энэ нь 2012 оны үлдэгдэл санхүүжилтээс Чингэлтэй дүүргийн татварын хэлтэст ХХОАТ-т шилжүүлсэн тооцоо байна. Энэ тооцоог суутган тооцох ёстой боловч суутгаагүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж, өр авлага үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д “...бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Төсвийн болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу Чингэлтэй дүүргийн татварын хэлтэстэй тооцоо нийлж, шийдвэрлэх зөвлөмж өгөх.

2.9.4. **Үндсэн хөрөнгийн талаар:**

2017 онд 20,000.0 мянган төгрөгийн компьютер, тоног төхөөрөмж худалдан авах төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 17,284.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан. Ингэхдээ Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас зохих журмын дагуу зөвшөөрөл аваагүй байна.

Энэ нь “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ыг зөрчсөн.

<u>Шийдвэрлэсэн нь</u>: Үндсэн хөрөнгө худалдаж авахдаа зохих хууль, журам, мөрдөх, цаашид зөрчил гаргахгүй байх зөвлөмж өгөх.

**2.10. Анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй болно.

**2.11. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд**

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан судалгааны санхүүжилт, гүйцэтгэлд нарийвчилсан горим хэрэгжүүлж чадаагүй. Дараагийн аудитаар авч үзнэ.

**2.12. Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл**

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 133,106.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх талаар удирдлагын анхааралд хандуулж зөвлөмж өгсөн болно.

**2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

ШУА-ийн харъяа хүрээлэнгүүд аудитын түвшинд хамрагддаг байсан тул Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2016 оны санхүүгийн тайланд аудит хийгдээгүй байна.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

**2.14. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Материаллаг байдлын түвшингийн суурийг тус байгууллагын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1 хувиар тооцож 19,300.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа. /ТАБ-СТА-В-1/

**2.15. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

**<u>АУДИТЫН ТАЙЛАНГ</u>**

БЭЛТГЭСЭН:

ЮНИСТАР АУДИТ ХХК-ИЙН

АХЛАХ АУДИТОР Б.ТЭРБИШ

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР Т.ЭНХТУЯА

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# ГАЗАРЗҮЙ, ГЕОЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

## МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

**Тэргүүлэх ач холбогдол № 1**

**Асуудал 1**

**Авлага**

**Асуудал 2**

**Бараа материал, үндсэн хөрөнгийн бүртгэл**

**Асуудал 3.**

**Урьдчилж гарсан тооцоо**

**Асуудал 4**

**Үндсэн хөрөнгө худалдан авах ажиллагаа**

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ





01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд хяналтын сул тал буюу горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга нь Аудитын олон улсын стандарт болон аудитûн горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн хэрэгжүүлдэг нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимд зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хяналт хийсэн бөгөөд оршин буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс бидний зөвлөмж дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний ойлголтыг тусгаж байгаа болно.

Эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд эдгээр зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан захирал, ерөнхий нягтлан бодогч болон бусад ажилтнуудад талархал илэрхийлье.

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ



01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**Асуудал 1: Авлага** — **Тэргүүлэх ач холбогдол №1**

Ажиглалт

Тайлант оны оны эцэст 118,053.58 мянган төгрөгийн авлагатай тайлагнасан. Жилийн эцсээр тус хүрээлэн авлагын үлдэгдлийг харилцагч нэг бүрээр тооцоо нийлж акт үйлдээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж, өр авлага үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д “...бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Эрсдэл

Авлага насжих тусам эргэлзээтэй, найдваргүй болох эрсдэл ихэсдэг. О,Т, Э,

Зөвлөмж

Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж, харилцагч тус бүрээр авлагын тооцоо нийлж, актаар баталгаажуулан, авлагаа барагдуулах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 10 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт албан тоотоор хүргүүлэх.

Үйлчлүүлэгчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авлаа, 2018 онд хэрэгжүүлж ажиллана.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ



ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
01
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**Асуудал 2: Бараа материал, үндсэн хөрөнгийн бүртгэл** **Тэргүүлэх ач холбогдол №1**

Ажиглалт

Бараа материалын дансанд 19,538.0 мянган төгрөгийн усалгааны систем, 3,500.0 мянган төгрөгийн хүлэмж зэрэг үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна. Мөн ашиглалтанд олгосон хангамжийн материалыг бараа материалын дансанд бүртгэгдсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 ”холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар...баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасантай нийцэхгүй байна.

Эрсдэл

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх. Т, Ү

Зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартын дагуу хөрөнгийг зөв ангилж бүртгэх, салбарын бүртгэлийн бодлогодоо нийцүүлэн өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон НБББББ боловсруулж мөрдөх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 10 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт албан тоотоор хүргүүлэх.

Үйлчлүүлэгчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авлаа, 2018 онд хэрэгжүүлж ажиллана.

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ





01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| Асуудал 3: Урьдчилж гарсан зардал | Тэргүүлэх ач холбогдол №1 |
|---|---|
| **Ажиглалт** | **Зөвлөмж** |
| Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл 6,033.8 мянган төгрөг нь 2012 оны үлдэгдэл санхүүжилтээс Чингэлтэй дүүргийн татварын хэлтэст ХХОАТ-т шилжүүлсэн тооцоо байна. Энэ тооцоог суутган тооцох ёстой боловч суутгаагүй.<br><br>Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж, өр авлага үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д “...бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” гэж заасантай нийцэхгүй байна. | Төсвийн болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу Чингэлтэй дүүргийн татварын хэлтэстэй тооцоо нийлж, шийдвэрлэх.<br><br>Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 10 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт албан тоотоор хүргүүлэх. |
| **Эрсдэл** | **Үйлчлүүлэгчийн хариу** |
| Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, батламж мэдэгдлүүд хангагдахгүй байх. | Зөвлөмжийг хүлээн авлаа, 2018 онд хэрэгжүүлж ажиллана. |

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ



01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| Асуудал 4: Үндсэн хөрөнгө худалдан авах ажиллагаа | Тэргүүлэх ач холбогдол №1 |
|---|---|

**Ажиглалт**

2017 онд 17,284.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авахдаа хууль журмын дагуу зохих зөвшөөрөл аваагүй.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 86 тоот тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ыг зөрчсөн.

**Зөвлөмж**

Үндсэн хөрөнгө худалдан авахдаа хууль журмын дагуу зохих зөвшөөрлийг авч байх, цаашид зөрчил гаргахгүй байх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 10 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт албан тоотоор хүргүүлэх.

**Эрсдэл**

Санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байх.

**Үйлчлүүлэгчийн хариу**

Зөвлөмжийг хүлээн авлаа, 2018 онд хэрэгжүүлж ажиллана.

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ





01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 218,240,700.93 | 188,035,402.29 |
| МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ | 5,595.00 | 5,595.00 |
| Кассанд байгаа бэлэн мөнгө | 5,595.00 | 5,595.00 |
| Төгрөг | 5,595.00 | 5,595.00 |
| АВЛАГА | 134,427,162.21 | 118,053,581.57 |
